

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ТЭРГҮҮЛЭГЧИД ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНААС 2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН
АЖЛЫН ТАЙЛАН
/2021.01.01 - 2021.12.23-ны байдлаар/**

2021 оны 12 дугаар сарын 23

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын алба тайлант онд Коронавируст халдвар (Ковид 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, цар тахалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, дүүргийн хүн амын эрүүл мэндийг дэмжихэд голлон анхаарч, хурлын байгууллагын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

Тайлант онд Хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, Хурлын хороодоос зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах, Авлигатай тэмцэх, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг тус тус боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байна.

1. Хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Тайлант хугацаанд Хурлын Тэргүүлэгчид дүүргийн Засаг даргаас өргөн барьсан 35, Хурлын Ажлын албанаас өргөн барьсан 51 асуудал нийт 86 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хурлын Тэргүүлэгчид өргөн барьсан асуудлын хүрээнд нийт 23 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 55 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээс 42 асуудал, цаг үеийн 24 асуудлыг тус тус хэлэлцэж, төлөвлөгөөний биелэлт 76,3 хувьтай байна.

Тайлант хугацаанд Хурлын Тэргүүлэгчид давхардсан тоогоор 71 тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хурлын Тэргүүлэгчдээс баталсан шийдвэрээс дурдвал:

1. Бодлогын баримт бичиг:

- Гэр бүл 2024 арга хэмжээ батлах тухай
- Соёлтой иргэн 2024 арга хэмжээ батлах тухай
- Чадварлаг багш 2024 арга хэмжээ батлах тухай
- Эрүүл Чингэлтэйчүүд 2024 арга хэмжээ батлах тухай
- Бүтээлч Чингэлтэйчүүд 2024 арга хэмжээ батлах тухай
- Ногоон дүүрэг 2024 арга хэмжээ батлах тухай

- Чингэлтэйд үйлдвэрлэв арга хэмжээ батлах тухай
- Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024 арга хэмжээ батлах тухай
- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймэрээс урьдчилан сэргийлэх 2024 арга хэмжээ батлах тухай
- Шинээр хороо байгуулах, зарим хэсэг, байршлыг шинэчлэх, хилийн цэст өөрчлөлт оруулах тухай санал дэмжих тухай
- Гамшгийн эрсдлийг бууруулах орон нутгийн зөвлөл байгуулах тухай

2. Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Нэг хаалга-нэг шинжилгээ арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх тухай
- Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд хэсгийн ахлагч нарыг ажиллах нөхцөлөөр хангах тухай
- Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх төсөл боловсруулан хэрэгжүүлэх чиглэл болгох тухай
- Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих тухай

3. Хяналт шалгалтын чиглэлээр:

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, зохион байгуулалтын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай
- Хурлын хороодыг хуралдуулах тухай
- Дүүргийн СӨБ болон бага, дунд боловсролын байгууллага, биеийн тамир, спортын хороо, спорт заал, цогцолборын үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Худалдан авах ажиллагааны ил тод байдал, цаашид авах арга хэмжээ
- Дүүргийн 2020 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт
- Улс, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний бэлтгэл ажил
- Дүүргийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт, цаашид авах арга хэмжээний тухай
- Дүүргийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний тухай
- Өвөлжилтийн бэлтгэл ажил, цаашид авах арга хэмжээний тухай
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын явц, цаашид авах арга хэмжээний тухай
- Дүүргийн статистикийн хэлтсийн үйл ажиллагаа, цаашдын зорилт
- Тайлан хэлэлцэх тухай

Тайлангийн хугацаанд Хурлын Тэргүүлэгчид хэлэлцсэн асуудлаар 41 заалт бүхий үүрэг, чиглэлийг Хурлын Ажлын албанд, 33 заалт бүхий үүрэг чиглэлийг

дүүргийн Засаг даргад, 4 заалт бүхий үүрэг чиглэлийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх хэлтэс, албадад тус тус хүргүүлээ.

Хурлын Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 90-100 хувь буюу бүрэн хангалттай биелэгдсэн 68, 50-89 хувь буюу хэрэгжих шатандаа 3 байна.

Тайлант хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 1, ээлжит бус 1 удаагийн хуралдааныг зохион байгуулж, цаг үеийн болон зохион байгуулалтын асуудлуудыг хэлэлцэн, 8 тогтоол шийдвэрийг баталлаа.

2. Хурлын хороодын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт:

Хурлын байгууллагын тасралтгүй, байнгын, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын хороод тайлант хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр 64 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 5 удаагийн удирдамж, төлөвлөгөөний дагуу 35 ажлыг зохион байгуулж, цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 29 ажил хойшилж, биелэлт 54,6 хувьтай байна.

Хурлын хороодоос зохион байгуулсан ажлаас дурдвал:

Эрх зүй, нутгийн удирдлагын хороо:

- “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээний төсөл
- “Гамшиг, эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх-2024” арга хэмжээний төсөл
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/

Эдийн засаг, төсвийн хороо:

- Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн 2020 оны төсвийн гүйцэтгэл
- Дүүргийн 2021 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/
- Дүүргийн 2022 оны төсвийн төсөл

Төсвийн зарцуулалтын хяналтын хороо:

- Дүүргийн 2020 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлж байгаа ажилтай танилцах

- Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаа, төлөвлөлт, гүйцэтгэлтэй танилцах
- Дүүргийн дотоод аудитын албаны үйл ажиллагаа, 2020 оны аудитын тайлан, аудитын зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажилтай танилцах
- Дүүргийн цахим татварын системийн үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдэх ажлын явц, гүйцэтгэлтэй танилцах
- Улс, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүрэгт 2020 онд хийгдсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, 2021 он, 2020-2021 он дамжин хийгдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилттэй танилцах
- Дүүргийн 2020 оны төсвийн гүйцэтгэл
- Дүүргийн 2021 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/
- Дүүргийн 2022 оны төсвийн төсөл

Ногоон хөгжил, газрын харилцааны хороо:

- “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээний төсөл
- Дүүргийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний явц, хэрэгжилттэй танилцах
- Дүүргийн Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний төсөл
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/

Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо:

- “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний төсөл
- “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээний төсөл
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/

Нийгмийн хөгжлийн хороо:

- “Чадварлаг багш-2024” арга хэмжээний төсөл
- “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний төсөл
- “Гэр бүл-2024” арга хэмжээний төсөл
- “Соёлтой иргэн-2024” арга хэмжээний төсөл
- “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний төсөл
- “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээний төсөл
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/

Ёс зүй, өргөдлийн хороо:

- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/

3. Хурлын Ажлын албанаас зохион байгуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба тайлант хугацаанд 57 ажил зохион байгуулахаас 51 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 6 ажил цаг үеийн байдлын улмаас хойшилж, биелэлт 89,4 хувьтай байна. Хурлын ажлын албанаас зохион байгуулсан ажлаас дурдвал:

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсны 29 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хууль батлалцсан Чингэлтэй дүүргийн харьяат, тухайн үеийн Ардын Их Хурлын депутатаар ажиллаж байсан Д.Мандах, М.Шийрав, Н.Гаравсүрэн, Г.Нороврагчаа нарыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Арван долдугаар жарны “Төмөр үхэр жил”-ийн сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон хороодын Иргэдийн Нийтийн Хурлын 13 ахмад дарга, дүүргийн харьяа ахмад настуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг олголоо.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 30 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрээр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийт 2000 иргэдээс санал ирүүлснийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжиллаа.

Олон улсын “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын 13 ахмад дарга нарт хүндэтгэл үзүүлж, хүлээн авах арга хэмжээг зохион байгууллаа. Түүнчлэн дүүргийн харьяат 90-ээс дээш насны 196 ахмадуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн зорилтууд ба нутгийн өөрөө удирдах байгууллагын манлайлал” сэдэвт нэг сарын аяны хүрээнд дүүргийн 7-19 дүгээр хороодын 30312 иргэнээс “Ариун цэврийн байгууламжийн талаарх” сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр авч, холбогдох тайлан, мэдээллийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцууллаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, идэвх оролцоог сайжруулах зорилгоор “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх нь” сэдэвт сургалтад дүүргийн 18-35 насны нийт 480 иргэнийг хамрууллаа.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн удирдамжийн хүрээнд Монгол Улсад Ардчилсан Шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан шатар сонирхогчдын “Дүүргийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тус тэмцээнээс шалгарсан эрэгтэй 3, эмэгтэй 3 шилдэг шатарчдыг “Нийслэлийн шатар сонирхогчдын Аварга шалгаруулах тэмцээн”-д оролцуулахаар нэрсийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж ажиллалаа.

4. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөл 2021 онд нийт 8 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 7 ажил бүрэн хэрэгжиж, биелэлт 88 хувьтай байна.

Тайлант хугацаанд нөхөн олговор хүссэн нийт 24 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст уламжлан, шүүхийн болон холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн 6 иргэнд 40 сая төгрөг, 1 иргэнд 80 сая төгрөгийн нөхөн олговрыг тус тус олгосон байна.

Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн бүртгэл судалгаанд хамрагдах иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч, тайлант хугацаанд нийт 146 иргэний бүртгэл судалгааг шинэчлэн баяжуулж, мэдээллийн санд бүртгэн ажиллалаа.

Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийн хүрээнд Хэлмэгдэгчдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн харъяат Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэд, тэдгээрийн гэр бүл, үр хүүхэд нийт 146 иргэнийг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Мөн өдрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэлтийн хор уршгийг ухуулан таниулах зорилготой арга хэмжээг дүүргийн харьяа 10 сургуулийн нийт 4302 сурагчдын дунд зохион байгууллаа.

5. Авлигатай тэмцэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Авлигатай тэмцэх газар, Хурлын байгууллагаас дэвшүүлсэн зорилтод тулгуурлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг эрчимжүүлэх, Авлигын эсрэг хууль тогтоомж, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлийн 3 бүлэг бүхий 8 ажлыг төлөвлөснөөс 7 ажил бүрэн хэрэгжиж, 1 ажил Ковид-19 цар тахлын улмаас хойшилж, хэрэгжилт 87,5 хувьтай байна.

Тайлант онд хуулийн үйлчлэлд хамаарах, хөрөнгө орлогын мэдүүлгээ бүртгүүлэх албан тушаалтны нэрсийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, нийт 46 албан

тушаалтны мэдүүлгийг цахимаар хүлээн авснаас Төрийн захиргааны 3, Төрийн үйлчилгээний 1, Төрийн Улс Төрийн 42 албан тушаалтан байна.

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд 1-19 дүгээр хороодын Иргэний танхимаар дамжуулан иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг “Өмгөөллийн Сүлд Эм Жи Легал” нөхөрлөлтэй хамтран зохион байгуулж, нийт 226 иргэн хууль, эрх зүйн туслалцаа авсан байна.

Түүнчлэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын авлигын тухай ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, шинэлэг санаа, бүтээлч шийдлийг дэмжих зорилгоор дүүргийн Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Миний оролцоо” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 30 сурагч материал ирүүлснээс шилдэг 6 оролцогчийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн 11 төрлийн зурагт хуудас, 11 видео шторкийг Хурлын албан ёсны цахим хуудас болон хороодын Иргэний танхимын цахим хуудаст байршуулж, давхардсан тоогоор нийт 66,140 иргэн хандаж мэдээлэл авсан байна.

6. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт:

Хурлын ажлын алба тайлант онд Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 3 бүлэг 13 ажил зохион байгуулахаас 12 ажил бүрэн хэрэгжиж, биелэлт 95 хувьтай байна.

Тайлант хугацаанд Хурлын Ажлын албаны Төрийн захиргааны 12, Төрийн үйлчилгээний 6, Улс төрийн 28 албан хаагчтай тус тус гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан нэмэгдэл хөлс, зэрэг дэв, шатлал ахиулах асуудлыг судлан шийдвэрлэх хүрээнд Төрийн захиргааны 3 албан хаагчид Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Төрийн захиргааны 4 албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, нэмэгдэл олгох ажлыг зохион байгууллаа.

Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм журамд заасны дагуу 11 албан хаагчийг өөрийнх нь хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлж, 16 албан хаагчийг Төрийн албанд шинээр томилж, 1 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр, Төрийн захиргааны 1 албан хаагчтай харилцан тохиролцсоны дагуу шилжүүлж, 4 албан хаагчид жирэмсний болон амаржсаны амралтыг олголоо.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд цаг үеийн эрэлт хэрэгцээ,

захиалгын дагуу дээд газраас зохион байгуулсан 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 58 албан хаагч, богино хугацааны гэрчилгээ олгох сургалтад 2 албан хаагч, байгууллагын албан хэрэгцээний хүрээнд зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 32 албан хаагчийг тус тус хамруулж, чадавхжуулж ажиллалаа.

7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2021 онд нийт 5 бүлэг бүхий 37 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 33 ажил бүрэн хэрэгжиж, 4 ажил цар тахлын улмаас хойшилж, биелэлт 89,1 хувьтай байна.

Тайлант хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Ковид-19 цар тахлын тархалттай холбогдуулан салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий 17 байгууллагын төлөөлөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ажиллаж байна.

Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2021 онд нийт 11 удаа хуралдаж, төлөвлөгөөт болон цаг үеийн 72 асуудлыг хэлэлцэн, 72 тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил иргэд, олон нийтийг татан оролцуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий сайн дурын 400 иргэд гудамж, байрны нийтийн эргүүлээр, 95 албан хаагч хорооны урьдчилан сэргийлэх багийн бүрэлдэхүүнд тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд гудамж, байрны нийтийн эргүүлүүдэд таних тэмдэг бүхий ажлын үнэмлэх, 250 хантаазыг шинэчлэн олгож, цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд ажиллахад нь дэмжлэг үзүүлж ариутгал, халваргүйтгэлийн бодис, хамгаалах хэрэгсэл, амин дэмээр тус тус хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, сар бүр ажилласан байдлыг нь харгалзан мөнгөн шагналаар шагнаж урамшуулж байна.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээллэх, сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр дараах аян, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- “Гэмт хэрэг, зөрчлөөс хамтдаа сэргийлье” 1,2 дугаар аян;
- “Гэр бүлийн хүчирхийлэлгүй Чингэлтэй” өдөрлөг;
- “Шийтгэл бол шийдэл биш” цахим аян;
- “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээ;
- “Ятгах тусам нягтал-2021” аян;
- “Мартаж болохгүй” нөлөөллийн аян;
- “Анхаар хүүхэд-Хариуцлагатай эцэг, эх” арга хэмжээ;

Дээрх аян, арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлаас дурдвал:

“Гэр бүлийн хүчирхийлэлгүй Чингэлтэй” өдөрлөгийн хүрээнд:

- “Хүчирхийлэлгүй гэр бүл хамгийн аз жаргалтай”, “Аз жаргалтай гэр бүл нийгмийн үнэт зүйл” сэдэвт 2 төрлийн богино хэмжээний видео шторк;
- “Гэр бүлийн хүчирхийлэлгүй Чингэлтэй” тараах материал, фейсбүүк преим, баннер, хулдаасан хэвлэл;
- “Гэр бүлийн хүчирхийлэлгүй Чингэлтэй” сэдвийн хүрээнд гар зураг, зохион бичлэг, эрдэм шинжилгээний өгүүллэгийн уралдаан;
- “Гэр бүлийн хүчирхийлэлгүй Чингэлтэй” сэдэвт гарын авлага;

“Шийтгэл бол шийдэл биш” аяны хүрээнд:

- “Уураар бус ухаанаар хүмүүжүүлье” сэдэвт харандааны адал явдлаар богино хэмжээний видео шторк;
- “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт 8 постер мэдээлэл;
- “Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал”, “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалал”, “Нийгмийн салбар дахь хүүхэд хамгаалал”, “Олон нийтийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал” зэрэг 5 сэдвийн хүрээнд мэргэжлийн хүмүүстэй хамтарсан подкаст ярилцлага;
- Дунд ангийн сурагчдын дунд “Нулимсгүй нүд”, “Ам биш амь”, “Гуниггүй нүд”, “Цар тахал манай гэрт”, “Би хаана жаргалтай байдаг вэ?” сэдвийн хүрээнд эсээ бичлэг болон постерийн уралдаан;

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд:

- “Байгалиа хамгаалъя” сэдэвт 1000 ширхэг гарын авлага;
- Ой хээрийн түймэр болон галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг бүхий 2 төрлийн зурагт хуудас;
- Дүүргийн 7-19 дүгээр хороодын ундны ус түгээх байрны хананд “Усаа хайрлаж, хамгаалъя” сэдэвт зураг;
- 17-р хорооны нутаг дэвсгэрт байрлах явган алхалтын газрыг бүрэн сэргээн засварлаж, ангилан ялгадаг хогийн сав, иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хогоо ил задгай хаяхгүй байгальд ээлтэй алхах талаар мэдээлэл бүхий төмөр самбар, амрах төмөр сандал байршуулсан.
- Чингэлтэй хайрханы Тахилтын аманд ангилан ялгадаг хогийн сав, хайрханы танилцуулга бүхий төмөр самбар, иргэд амрах төмөр сандал шинээр хийж байршууллаа.

“Гэмт хэрэг, зөрчлөөс хамтдаа сэргийлье” ажлын хүрээнд:

- “Чингэлбаатар хүүгийн зөвлөмж 1,2” зурагт цуврал ном;
- “Хүүхдэд ээлтэй жолооч” видео шторк, хөөсөн самбар, зурагт наалт;
- “Архидалт болон бусад догтол, түүнээс үүдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт ном;

- “Чингэлбаатар хүү өсвөрийн сэргийлэгч болсон нь” цуврал зурагт ном;
- “Чингэлбаатар найздаа тусалсан нь” цуврал зурагт ном;
- “Ятгах тусам нягтал-2021” аяны хүрээнд видео шторк, зурагт хуудас, тараах материал;
- “Хөдөлгөөний соёл-2021” сэдэвт видео шторк, зурагт хуудас, хулдаасан хэвлэл;

“Анхаар хүүхэд - Хариуцлагатай эцэг, эх” арга хэмжээний хүрээнд:

- “Анхаар хүүхэд” 35 ширхэг замын тэмдэг, тэмдэглэгээ;
- “Анхаар хүүхэд” видео шторк, 40000 ширхэг зурагт хуудас;

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх хүрээнд дараах байгууллагуудад техник, тоног төхөөрөмжийн туслалцаа, дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үүнд:

- “Нэг хаалга-Нэг шинжилгээ” бүх нийтийн арга хэмжээний хүрээнд хууль хяналтын байгууллагын хурдан шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Цагдаагийн газрын нийт 73 ажилтан, албан хаагчдад гар утасны цэнэглэгч карт, түргэвчилсэн оношлуур;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай техник, хэрэгслээр хангах хүрээнд 40 ширхэг гар станцыг дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтэст;
- Дүүргийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэст “Чингэлтэй дүүрэг дэх зам тээврийн ослын нөхцөл байдал” сэдэвт судалгааны ном;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн байранд онлайн шүүх хурлын заал, сургалтын танхим тохижуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж;
- Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн байранд “Алсын зайн эрх зүйн сургалтын өрөө”-г тохижуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж;
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд хурдан, шуурхай үйлчлэх, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх, гэр хохирогчийг түр хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвд нэн шаардлагатай автомашин, түргэвчилсэн оношлуур, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл;
- Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах үүрэг бүхий гудамж, байрны нийтийн эргүүлүүдэд 670 ширхэг ариутгал, хамгаалалтын багц;
- Дүүргийн 1-19 дүгээр хороодын Улсын бүртгэгчдэд үнэт цаас болон эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хувь хүний нууц алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нууцлал, аюулгүй байдлын хамгаалалттай цүнх;
- Ахуйн гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Мартаж болохгүй” нөлөөллийн аяны хүрээнд дүүргийн Онцгой байдлын хэлтэст шаардлагатай техник хэрэгсэл, гарын авлага, тараах материал;

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тайлангийн хугацаанд Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд байгууллага, иргэдээс цахим болон албан бичгээр нийт 343 бичиг тоот хүлээн авснаас 331 бичиг тоотыг хуульд заасан хугацаанд бүрэн шийдвэрлэж, 12 бичиг шийдвэрлэх шатандаа байна. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 357 бичиг тоотыг хүргүүлэн ажиллалаа.

Ирсэн бичгийг ангилбал:

- Дээд газраас -91
- Дүүргийн Засаг дарга түүний Тамгын газар-58
- Дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх хэлтэс албад, хороодоос-112
- Аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагаас-30
- Бусад-5

Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд иргэдээс 8 өргөдөл, 2 хүсэлт хүлээн авснаас 3 өргөдөл, 2 хүсэлтийг Хурлын Ажлын алба эрхлэх асуудлын хүрээнд бүрэн шийдвэрлэж, 3 өргөдлийг дүүргийн Засаг дарга түүний Тамгын газарт цахимаар шилжүүлсэн байна.

Шашин сүм хийдтэй харилцах чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын судалгааг жил тутам шинэчлэн боловсруулж, тайлант хугацаант 15 хороонд 38 шашны байгууллага зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дээрх 38 байгууллагуудад үйл ажиллагааг нь хязгаарласан талаарх мэдээллийг хүргүүлж, хяналт тавин ажиллах талаар хороодын Засаг дарга нарт 3 удаа албан тоотоор зөвлөмж, чиглэл хүргүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүссэн 16 байгууллагын өргөдөл, хүсэлтийг судлан үзэж, 4 байгууллагын өргөдөл хүсэлтийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Түр журам”-ын хэрэгжилтийг хангах, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 14 дүгээр захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт шашны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, шалгалтаар илэрсэн 211 зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг чиглэл өгч, тайлан, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа.

Хурлын Тэргүүлэгчид Төрийн дээд шагнал, цол, одон, медиалаар шагнуулахаар байгууллага, иргэдээс ирүүлсэн Чингэлтэй дүүргийн харьяат 552 иргэн, “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат 416 эхийн тодорхойлолт материалыг тус тус хэлэлцэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулан, идэвх санаачилгатай ажиллаж байгаа Чингэлтэй дүүргийн харьяат 556 иргэний тодорхойлолт материалтай танилцаж 490 иргэнийг Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор, 66 иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшууллаа.

Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн дүүргийн 1 дүгээр хорооны иргэн Балжиннямын Жамъян, 15 дугаар хорооны иргэн Маамын Тогоо нарыг Нийслэл, дүүргийн хөгжилд оруулсан үнэтэй хувь нэмэр, амжилт бүтээлийг нь өндрөөр үнэлж Чингэлтэй дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөн алдаршууллаа.

Тайлангийн хугацаанд Хурлын дарга Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар 18 захирамж, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга үндсэн үйл ажиллагаатай холбоотой 128, боловсон хүчинтэй холбоотой 172, нийт 300 тушаал, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Коронавируст халдварын цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагаа цахим хэлбэрт тулгуурлан хэрэгжиж байна.

Тайлант хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудын хамтарсан туршлага солилцох сургалтыг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд Хурлын Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидтойгоо ажиллах нөхцөлийг бүрдүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, оролцоог нь хангах чиглэлээр цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан дүүргийн хүн амыг халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилтнуудад 35 сая төгрөгийн үнэ бүхий хамгаалах хувцас хэрэглэл, халуун хэмжигч гар ариутгагч аппарат, амны хаалт, нэг удаагийн бээлий, зөөврийн хүчилтөрөгчийг хүлээлгэн өглөө.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Тэргүүлэгч, Төлөөлөгчид сонгогдсон тойрог, хорооныхоо Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч болон хэсгийн ахлагч, нийтийн эргүүлүүдэд дархлаа дэмжих “Амин дэмийн багц” бүтээгдэхүүнийг олголоо.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачилсан “Өрх бүр хашаандаа мод тарья” аян болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум” мод тарих үндэсний хөдөлгөөнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Тэргүүлэгчид, Хурлын Төлөөлөгчдийг хамруулж, идэвх оролцоог хангаж ажиллалаа.

Хурлын эмэгтэй Төлөөлөгчдийн манлайллыг дэмжих, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах чиглэлээр Иргэний боловсролын төв, Каритас Чех републик төрийн бус байгууллага, Монголын Залуучуудын Эвсэл хамтран хэрэгжүүлж буй “Бүгд Залуусын төлөө Залуус бүгдийн төлөө” төслийн сургалтад Хурлын Төлөөлөгч Д.Уянга, Ч.Мягмарсүрэн, Ж.Булганцэцэг, Б.Болортунгалаг нар хамрагдлаа.

Хурлын Төлөөлөгчдөд мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх, цаг үеийн мэдээ, мэдээллээр шуурхай хангах чиглэлээр “Мэдээллийн цаг” арга хэмжээг 14 хоног тутамд зохион байгуулж, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны үйл ажиллагаатай танилцаж, 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2022 оны төлөвлөгөөнд цахим хэлбэрээр хэрхэн санал өгөх талаарх заавар, зөвлөмжийг хүргэж, мэдээллээр хангалаа.

Түүнчлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран дүүргийн хэмжээнд нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаатай танилцаж, цаг үеийн мэдээ, мэдээллээр хангалаа.

Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Монгол Улсын Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны дарга болон ажилтан, албан хаагчид оролцлоо.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд Хурлын Төлөөлөгчид бодлого шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цар тахлын нөхцөл байдлын талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрт цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас Олон нийттэй харилцах чиглэлээр тайлант онд 2 бүлэг 23 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөснөөс 21 ажил бүрэн хэрэгжиж, цар тахлын улмаас 1 ажил хойшилж, биелэлт 91,3 хувьтай байна.

Дэлхий нийтэд тархаж буй шинэ коронавируст халдвар /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан иргэд, олон нийтийг хамарсан хурал, уулзалт, сургалт, үйл ажиллагаа хойшлогдоод байна.

Тайлант хугацаанд хороодын Иргэний танхимаар дамжуулан иргэдээс 1794 санал, хүсэлт ирүүлснээс цахимаар 654, утсаар 1112, биечлэн 25, бичгээр 3 санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагад уламжиллаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дүүргийн 1-19 дүгээр хорооны Иргэний танхимын ажилтнууд гудамж, байрны нийтийн эргүүлүүдийг шуурхай ажиллуулж, дүүргийн иргэд, айл өрх, албан байгууллагыг цар тахлаас урьдчилан сэргийлэх, албан байгууллагуудад бүртгэлийн QR код ашиглах талаар заавар, зөвлөмжийг биечлэн хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгууллаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг анхан шатны нэгжид төлөвшүүлэх зорилтын хүрээнд хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчдийг чадавхжуулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор шинээр батлагдаж буй Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар цахим сургалт зохион байгууллаа.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ:

Тайлант хугацаанд Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт, зохион байгуулсан үйл ажиллагаа болон цаг үеийн бусад 142 удаагийн мэдээ, 108 цагаан мэдээ, 35 видео шторк, 96 постер, 11 мэндчилгээг бэлтгэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар, www.chingelteicouncil.mn веб сайтаар 79 мэдээ, Тэргүүлэгчдийн тогтоол 33, www.chingeltei.ub.khural.mn веб сайтаар 79 мэдээ, мэдээллийг байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан ажилласан байна. www.chingelteicouncil.mn цахим хуудсанд давхардсан тоогоор 756,312, www.chingeltei.ub.khural.mn цахим хуудсанд 1,213,512, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар 1,200,520 хэрэглэгч хандаж мэдээлэл авсан байна.

Хурлын байгууллагаас баталсан шийдвэр, үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн цахим оролцоо, санал санаачилгыг хүлээн авах зорилгоор 1-19 дүгээр хороодын Иргэний танхимын цахим хаягт байршуулсан мэдээлэл, иргэдийн хандалтын тайланг сар бүр нэгтгэж, мэдээллийн үр дүнг тооцон ажиллаж байна. Тайлант хугацаанд Иргэний танхимын цахим хаягаар нийт 27261 удаагийн мэдээ мэдээлэл бэлтгэн нийтэлж, давхардсан тоогоор 229,809 иргэний хандалт авч, иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Дүүргийн 1-19 дүгээр хорооны цахим хуудсанд иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн агуулгыг сурталчлан таниулах чиглэлээр 2265, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 5039, нийгмийн халамжийн чиглэлээр 1763 мэдээ, цаг үеийн бусад 18174 мэдээ, мэдээллийг байршуулж, иргэд, олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах хүрээнд Хурлын байгууллагын санхүүгийн сар, улирлын гүйцэтгэлийн тайлан, мэдээг тогтсон хугацаанд Шилэн

дансанд тогтмол байршуулж, иргэд, олон нийтийн мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

**ДӨРӨВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ
АЖИЛЛАГАА:**

Хурлын Ажлын алба тайлант хугацаанд Монгол Улсын Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлыг зохион байгууллаа.

Хурлын Тэргүүлэгчид тайлант онд цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр 4 удаа цахим хэлбэрээр хуралдаж, дараах шийдвэрүүдийг баталж, хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Дүүргийн 1-19 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарт гар утасны цэнэглэгч карт олгож, ажиллах нөхцөлөөр хангах тухай;
- Дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч сувилагч, 1-19 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарт гар утасны цэнэглэгч карт олгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх тухай;
- Дүүргийн хүн амыг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэл бүхий нөхцөлд ажиллаж буй албан хаагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр төсөл боловсруулан хэрэгжүүлэхийг Хурлын хороодын дарга нарт чиглэл болгох тухай;
- Эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэх явцдаа коронавирусын халдвар авч өвдсөн, дархлаажуулалтад хамрагдах боломжгүй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, эмчилгээнд хамруулах тухай;

Иргэн болон ажилтныг халдвараас сэргийлэх нөхцөлийг эрх бүхий байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу бүрдүүлэх хүрээнд:

Бүх нийтийн хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тусгаарлалтын дэглэмд шилжсэнтэй холбогдуулан Хурлын Ажлын албаны нийт ажилтан, албан хаагчдын 15-30 хүртэлх хувийг цахим хэлбэрээр ажиллуулж, байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

Цар тахлын үед эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байхдаа коронавирусын халдвар авсан төрийн албан хаагчид нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх хүрээнд:

Цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа коронавирусын халдвар авч, эмчилгээ хийлгэсэн Хурлын Ажлын албаны нийт 30 албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор эмчилгээний зардалд нь дэмжлэг үзүүлж нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж, дархлаажуулалтад хамрагдах боломжгүй болон эрүүл мэндийн суурь өвчтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын Төлөөлөгч, Ажлын албаны ажилтан, албан хаагчдыг хүчилтөрөгчийн эмчилгээнд хамруулах, нийт ажилтнуудад амин дэмийн багц олгох ажлуудыг тус тус зохион байгууллаа.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах хүрээнд:

Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт шинжилгээ авах цэгүүдийн байршлын талаарх мэдээлэл өгөх 7000-7105, хорооны Иргэний танхимын “Та дохь-би залгая” 94110361-94110379 шуурхай дуудлага хүлээн авах утасыг ажиллуулж, иргэд олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж байна.

Дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн 153 эмч, сувилагч, 1-19 хороодын 194 хэсгийн ахлагч, Цагдаагийн газрын 73 алба хаагчдад гар утасны цэнэглэгч карт тус тус олгож, ажиллах нөхцөлөөр хангаж ажиллалаа.

Цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах ажлын хүрээнд:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын санаачилсан төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүн амыг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Үүнд:

- Дүүргийн Эрүүл мэндийн төвд иж бүрэн хүчилтөрөгчийн аппарат 2 ширхэг;
- 1-19 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд зөөврийн хүчилтөрөгчийн баллон 12 ширхэг;
- Эмч, сувилагч нарт N94, N95 маск 6734 ширхэг, халуун хэмжигч, гар ариутгагч аппарат 22 ширхэг, хамгаалах хувцас 323 ширхэг;

Цар тахлын эсрэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөгөө авах, хандив, тусламж өгөх хүрээнд:

- Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс Ковид-19 халдварын батлагдсан тохиолдлыг гэрээр очиж үнэлэх, эмнэлзүйн шинж тэмдэг бүхий иргэдийг эмнэлэг рүү тээвэрлэн хүргэх дуудлагын багт Хурлын Ажлын албаны автомашин болон шатахууны зардлын дэмжлэг үзүүллээ.
- Дүүргийн Онцгой комиссын шуурхай штабын дуудлага, мэдээлэл хүлээн авах төвд 4 ширхэг суурин утас болон төлбөр тооцооны асуудлыг бүрэн хариуцан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түр хамгаалах байр, хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалт болон 24 цагаар ажиллуулах утасны санхүүжилтыг шийдвэрлэх хүрээнд:

- Цар тахлын хорио цээрийн дэглэмийн үед гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн гаралт өссөнтэй холбогдуулан дүүргийн 1-19 хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багуудын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлээ.
- Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд “Аз жаргалтай гэр бүл, нийгмийн үнэ цэнэ”, “Уураар бус ухаанаар хүмүүжүүлэе” сэдэвт богино хэмжээний видео шторкийг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж, цахим сүлжээнд байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Шийдвэр, арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээллэх хүрээнд:

“Ковид 19 цар тахлаас хамтдаа сэргийлье” сэдэвт богино хэмжээний видео шторкийг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж, цахим сүлжээнд байршуулж, иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар, Улс, Нийслэл, дүүргийн Онцгой комисс болон Хурал, Тэргүүлэгчдээс цар тахалтай тэмцэх чиглэлээр баталсан тогтоол, шийдвэрүүдийг тухай бүрт дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудаст байршуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээ мэдээлэл 45, уриалга бүхий 3 постерыг тус тус бэлтгэн, олон нийтийн сүлжээнд байршуулан ажиллалаа.

Төсвийн жилд (2021 он) төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн МУ-ын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийн ажиллаж байна.

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА